Мэдэгдэл

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Огноо 2014 оны 5-р сарын 20

Хэнд: Нэгдсэн Улс болон Канадаас бусад орон дахь Ерөнхий эрх мэдэлтнүүд болон дараах удирдагчид; Бүсийн далууд, Гадас, Номлол болон Дүүргийн ерөнхийлөгч; бишоп ба салбарын ерөнхийлөгчид

Хэнээс: Гэр бүлийн түүхийн алба ба Тасралтгүй Боловсролын Сангийн Алба

Сэдэв: Гэр бүлийн түүхийн төвийн барилга байгууламжийг Бие даах чадвар хөгжүүлэх төвтэй хамтран ашиглах нь

Гэр бүлийн түүх болон Бие даах чадвар хөгжүүлэх төвийн аль алинд нь хамаатай техник технологи ба эх сурвалжуудад нэвтрэх гишүүдийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахын тулд зарим Гэр бүлийн төвүүдэд байгаа тоног төхөөрөмж болон талбайг Тасралтгүй Боловсролын Сангийн Бие даах чадвар хөгжүүлэх төвтэй хамтран ашиглана. Гэр бүлийн түүхийн төв болон Тасралтгүй Боловсролын Сангийн Бие даах чадвар хөгжүүлэх төв нь өөрсдийн хуваарийг зохицуулан, тус тусдаа (1) гишүүд болон бусдыг гэр бүлүүдээ олж мэдэхэд нь мөн гишүүдийг гэр бүлийнхнийхээ нэрсийг ариун сүмийн ёслолуудад илгээхэд нь туслах (2) гишүүдийг боловсрол эзэмших, ажил олох, бие даан ажилладаг болох боломжуудыг хүлээн авахад нь туслах болно.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл хавсаргасан удирдамжийн дагуу эдгээр төвийг хэрхэн ашиглахыг зохион байгуулах хэрэгтэй. Нэмэлт мэдээлэл авах бол бүсийн Гэр бүлийн түүх эсвэл Бие даах чадвар хөгжүүлэх төвийн менежертэй холбоо барина уу.

Гэр бүлийн түүхийн төвийн барилга байгууламжийг Бие даах чадвар хөгжүүлэх гадасны төвтэй хамтран ашиглах тухай удирдамж

2014 оны 5-р сарын 1

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Дараах удирдамжийг гэр бүлийн түүхийн төвүүдэд зориулан өмнө нь гаргасан журмууд дээр нэмж оруулсан.

1. **Зорилго:** Гэр бүлийн түүх болон бие даах чадвар хөгжүүлэх төв нь тус тусын зорилгодоо хүрэхийн тулд хамтран ажиллах хэрэгтэй.
2. **Үүрэг хариуцлага:** Санваарын удирдагчийн удирдлаган дор Гэр бүлийн түүхийн төвийн захирал нь Гэр бүлийн түүхийн албаны журмын дагуу уг төвийн үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжүүдийг хариуцан голлох үүрэг хүлээнэ. Тус төвийн захирал Бие даах чадвар хөгжүүлэх төвийн хэрэгцээ хангагдаж байгаа эсэхийг мэдэхийн тулд Бие даах чадвар хөгжүүлэх гадасны мэргэжилтэнтэй хамтран ажиллах хэрэгтэй.
3. **Хуваарь:** Гэр бүлийн түүхийн төвийн захирал болон Бие даах чадвар хөгжүүлэх гадасны төвийн мэргэжилтэн нар санваарын удирдагчидтай зөвлөлдөн, тус төвийн хуваарийг хамтран гаргана. Шаардлагатай бол Гэр бүлийн түүх болон Бие даах чадвар хөгжүүлэх төвийн аль аль нь зорилгодоо хүрэхэд нь ажилтнууддаа байнга туслах зорилгоор үйл ажиллагаа бүрд зориулан тус тусдаа үйл ажиллагааны цаг гаргаж болно.
4. **Хүний нөөц:** Гэр бүлийн түүхэд томилогдсон дээд зөвлөлийн гишүүн болон Бие даах чадвар хөгжүүлэх гадасны төвийн хороо нь хоёр төвийн үйл ажиллагаанд хүний нөөцийн хэрэгцээ хангагдаж байгаа эсэхэд анхаарна. Гэр бүлийн түүхийн төвийн захирал болон Бие даах чадвар хөгжүүлэх гадасны мэргэжилтэн нар ажилтнуудынхаа хуваарь болон сургалтыг хамтран зохицуулна. Зарим тохиолдолд хоёр төвийн үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг хангахын тулд хүний нөөцөө хоршин ашиглах, сургалт өгөх хэрэгцээ гарч болно.
5. **Барилга байгууламж ба тоног төхөөрөмжөө хамтран ашиглах нь:** Бие даах чадвар хөгжүүлэх үйлчлэл нь гэр бүлийн түүхийн үйл ажиллагааг орлохгүй ч гэр бүлийн түүхийн төвийн одоо ашиглаж буй талбай, тавилга болон тоног төхөөрөмжүүдийг хамтран ашиглана. Шаардлагатай бол зохион байгуулагдсан гэр бүлийн түүхийн төвийн үйл явцыг ашиглан, шинэ барилга байгууламж эсвэл тоног төхөөрөмжийн хүсэлт гаргаж болно. Төвүүд нь Барилгын албаны болон гадасны техникийн мэргэжилтний тусламжтайгаар Гэр бүлийн түүхийн Албаны баталсан компьютер болон бусад тоног төхөөрөмжийг ашиглана. Мөн төвүүд нь Гэр бүлийн түүх болон Тасралтгүй Боловсролын Сангийн баталсан программ хангамж болон бусад эх сурвалжийг ашиглаж болно. Төвүүд дэх компьютер болон интернэтийг *Гарын авлага 1: Гадасны ерөнхийлөгч болон бишопууд* (2010), 17.1.12 мөн *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 21.1.22. номон дээрх журмуудын дагуу ашиглана. Гэр бүлийн түүхийн төв болон бие даах чадвар хөгжүүлэх үйлчлэл нь байр болон тоног төхөөрөмжөө харж хамгаалах үүргийг адил тэгш хүлээнэ.

6. **Бусад зүйлс (Бие даах чаадвар хөгжүүлэх загвар төв):** Гэр бүлийн түүхийн цөөн хэдэн төв нь долоо хоногт 40 ба түүнээс дээш цаг ажиллах шаардлагатай бөгөөд "Бие даах чадвар хөгжүүлэх загвар төв"-тэй талбайгаа хамтран ашиглана. Эдгээр төвд бие даах чадвар хөгжүүлэх төвийн зорилгыг биелүүлэхийн тулд том байр, илүү олон ажилтан, тоног төхөөрөмж шаардагдаж болно. Тасралтгүй Боловсролын Сангийн Албанаас хангасан эдгээр нэмэлт тоног төхөөрөмжийг Азийн бүсийн албаны ICS алба засаж, зохион байгуулна. Эдгээр төв нь илүү сайн уялдаа холбоотой ажиллах шаардлагатай бөгөөд үүрэг хариуцлага, үйл ажиллагаандаа зарим нэг өөрчлөлт оруулах хэрэгтэй байж болно.